

...

13.1. Суралцагч дор дурдсан эрх эдэлнэ.

13.1.1. Суралцагчид нь сургалтын чанар үр дүн, хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар санал гомдлоо анги удирдсан багш, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн захиргаанд тавьж, шат дараалах зарчмыг баримтлан шийдвэрлүүлнэ.

13.2. Суралцагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ.

13.2.1. Сургууль, анги танхим, сургуулийн хонгилд болон багш, ажилтан, ахмад хүмүүс, дүү, найз нөхдөө хүндэтгэн зохих хууль, дүрэм, журмыг чанд сахих;

13.2.2. Суралцагч нь багш, ажилтны тавьсан зүй ёсны шаардлагыг биелүүлэх, зүй бусаар харилцахгүй байх /хэнэггүй зан гаргах, биеэ тоох, ёс бус үг хэлэх гэх мэт/;

13.2.3. Боловсролын хуулинд заасан суралцагчдын үүрэг, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан суралцагчдын дүрэм болон эцэг эх, сургууль, суралцагчийн байгуулсан гуравласан гэрээг чанд биелүүлэх, хэрэв зөрчсөн тохиолдолд шат дараалсан арга хэмжээг авна;

13.2.4. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээл таслах, хоцрохгүй байх;

13.2.5. Зодоон хийх, хэрүүл маргаан дэгдээх, бусдын эд зүйлсийг булаан авах, хулгай хийх, согтууруулах ундааны зүйл хэрэглэх, тамхи татах;

13.2.6. Анги танхимд гүйх, хашгирах, ноцолдохгүй байх, сургууль дээр тэсэрч дэлбэрэх болон хутга мэс, гал шүдэнз гэх мэт зүйл авч ирэхгүй байх;

13.2.7. Хариуцсан анги кабинетэд чийгтэй цэвэрлэгээг тогтмол хийж, сургуулийн эд хогшил, аж ахуйг эвдрэлгүй ашиглах, хамгаалах, эвдэлсэн үед засаж элбэн хохиролгүй болгох;

13.2.8. Сургуулийн эд хогшил, сургалтын техник хэрэгслийг ашиглахдаа хариуцсан багш, ажилтнаас зөвшөөрөл авах;

13.2.9. Суралцагч нь дүрмийн бус хувцаслахгүй байх /гаж буруу хувцаслах, хэт гангарах, будаг хэтрүүлэн хэрэглэх/ үүрэгтэй.

13.3. Сурагч нь улиралд 20-оос дээш цагийн таслалттай бол сурагчдын өөрөө удирдах зөвлөлийн, 40-өөс дээш цагийн таслалттай бол захирлын дэргэдэх зөвлөлийн, 60-аас дээш цагийн таслалттай бол багш нарын зөвлөлийн хурлаар оруулан цаашид суралцах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

13.4. Архи, тамхи, мансууруулах ундаа хэрэглэсэн, бусдын болон байгууллагын эд зүйлсийг хулгайлбал сургуулиас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

13.5. Сургуулийн дотоод журам, суралцагчийн дүрэм зөрчсөн суралцагчийн зөрчил, дутагдал, доголдлын хэм хэмжээг харгалзан:

13.5.1. Сануулах;

13.5.2. Анги хамт олны хурлаар хэлэлцэж, хувийн хэрэгт тэмдэглэх;

13.5.3. Багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хамт олны дунд сургах эсэх асуудлыг шийдвэрлэх;

13.5.4. Гэрээ цуцлах.

...